



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ



Хэрэгжүүлэгч :

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих (ICED) төсөл

Улирал тутмын мэдээллийн товхимол
№ 2/2024



СОЛОНГОС- МОНГОЛЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧИД ТҮНШИЛНЭ

Нийслэлийн ЖДҮҮ Дэмжих төв, GIZ-ийн ICED төсөл болон Монголын бизнес эрхлэгчдийн төлөөлөл Бүгд Найрамдах Солонгос Улсад (БНСУ) 2024 оны 4-р сарын 15-20-ны өдрүүдэд айлчлав.

Солонгосын бизнес эрхлэгчийг дэмжих байгууллага IMI-тай (International Management Investment) хамтран зохион байгуулсан аяллын зорилго нь Солонгос–Монголын бизнес форумыг зохион байгуулах, хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжихэд оршиж байв.



Бизнес аяллын үр дүнг товчоор дурдвал:

- **Солонгос–Монголын бизнес форумыг** амжилттай зохион байгуулж хоёр орны бизнес эрхлэгчид ирээдүйн хамтын ажиллагаа, түншлэл, салбар бүрийн худалдаа, хөрөнгө оруулалтын боломжуудыг хэлэлцэж, тодорхой тохиролцоонд хүрэв.
- Нийслэлийн ЖДҮҮ Дэмжих төв нь IMI-тай **Хамтын ажиллагааны гэрээнд** гарын үсэг зурлаа. Хоёр жилийн хугацаатай энэхүү гэрээ нь хоёр орны жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийн харилцаа тогтоох, хөрөнгө оруулалтыг дэмжих, бизнес уулзалт, аялал, үзэсгэлэн, арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх эрх зүйн үндэслэл болох юм.
- **Монголын Худалдааны Агентлаг (MOTRA)**-ийг БНСУ-д албан ёсоор байгуулав. Худалдааны агентлаг нь хоёр орны эдийн засгийн, тэр дундаа ЖДҮ эрхлэгчдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, бизнесийн сүлжээ байгуулах, дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлээр ажиллана.
- Бизнес аяллын 35 оролцогчид БНСУ-ын жижиг, дунд үйлдвэрүүдэд зочилж, үйл ажиллагаатай нь танилцав. Мөн B2B уулзалтуудыг зохион байгуулж, бизнес эрхлэгчид харилцан яриа өрнүүлэх, ирээдүйн хамтын үйл ажиллагааны үндэс суурийг тавих, шинэ санаа, туршлага солилцсон нь амжилттай түншлэлийг эхлүүлэхэд дэмжлэг боллоо.

GIZ-ийн ICED төсөл нь тус аялалд техникийн туслалцаа үзүүлж, худалдааны агентлаг байгуулах зорилго, концепт боловсруулах, үйл ажиллагааны чиглэл тодорхойлоход хамтран ажиллав.

“БИЗНЕСИЙН СЭРГЭЛТ-БАРУУН БҮСИЙН ФОРУМ” ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ

Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ), тус яамны Хөрөнгө оруулалт худалдааны газар (ХОХГ), Увс аймгийн Засаг даргын Тамгын газар, МҮХАҮТ хамтран “Бизнесийн сэргэлт-Баруун бүсийн форум”-ыг 2024 оны 4-р сард Увс аймагт зохион байгууллаа.

Энэ форум нь баруун бүсийн эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих, хил дамнасан худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилготой байв.

Баруун бүсийн аялал жуулчлал, тээвэр логистик, хөдөө аж ахуй зэрэг салбарын хөгжлийг талаар хэлэлцсэн форумын үеэр Увс, Завхан, Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн 300 гаруй бизнес эрхлэгчид орон нутгийн онцлогийг шингээсэн, брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа гарав.

Форум болон үзэсгэлэн худалдаанд хил залгаа ОХУ болон БНХАУ-аас 60 гаруй төлөөлөл, зочид хүрэлцэн ирж оролцлоо. Форумын үеэр хил залгаа гурван орны ЖДҮ эрхлэгчдийн ирээдүйн хамтын ажиллагааг дэмжих уулзалтуудыг зохион байгуулав. GIZ -ийн ICED төсөл бизнес эрхлэгчдийн уулзалтуудыг зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлэв.



ЖДҮ ЭРХЛЭГЧДИЙН ДИЖИТАЛ ШИЛЖИЛТИЙГ ДЭМЖИНЭ

Нийслэлийн ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаанд дижитал технологид суурилсан үйлчилгээ, дижитал системийн хэрэглээг хөгжүүлэн нэвтрүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах зорилготой “Digital SME” форум 2024 оны 5-р сарын 29-ний өдөр болов.

Нийслэлийн ЖДҮҮ Дэмжих төвөөс хоёр дах жилдээ зохион байгуулж байгаа энэ арга хэмжээг GIZ-ийн ICED төсөл, Голомт банк дэмжин, хамтран зохион байгууллаа. “Digital SME” форумд нийт 180 гаруй ЖДҮ эрхлэгчид оролцож, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт дижитал шилжилтийг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагаа тодорхойлж, боломжуудаа хэлэлцлээ.

Мөн тус форум үеэр ЖДҮ эрхлэгчдийг чадавхжуулах, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, дижитал технологи ашиглан санхүүгийн дэмжлэг үзүүлэх чиглэлд Нийслэлийн ЖДҮҮ дэмжих төв, GIZ-ийн ICED төсөл, Голомт банк цаашид хамтран ажиллахаар Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.



"NATIONAL STARTUP CHALLENGE MONGOLIA -2024" ТЭМЦЭЭН БОЛЛОО



Дижитал үйлдвэрлэл нь нүсэр дэд бүтэц, хөрөнгө оруулалт шаарддаггүй, цаг хугацаа, газарзүйн хувьд хил хязгааргүй онцлогтой үйлдвэрлэл бөгөөд уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбаруудын зэрэгцээ манай улсын экспортын томоохон боломж бүхий салбар болон хөгжиж байна.



Монголын Мэдээллийн Технологийн Үндэсний Парк, "СМС маркетинг спейс" байгууллагатай хамтран мэдээллийн технологийн экспортыг дэмжих, Монголын анхны Юникорн компаниудыг үүсгэх зорилго бүхий "National Startup Challenge Mongolia 2024" тэмцээнийг санаачлан 2024 оны 4-5-р саруудад амжилттай зохион байгууллаа. "National Startup Challenge Mongolia" нь мэдээллийн технологийн шилдэг гарааны бизнес эрхлэгчид, энтрепренёрууд, шинийг санаачлагчид, хөрөнгө оруулагчид, бодлого боловсруулагчдын хувьд шинэлэг санаа, шинэлэг шийдлүүдийг танилцуулдаг тэргүүлэх талбар юм.



Тус тэмцээн нь үндэсний хэмжээнд зохиогддог ижил төрлийн тэмцээнүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр буюу 300-500 сая төгрөгийн шагналын сантай байлаа. Тэмцээнд шалгарсан баг нь Монгол Улсаа төлөөлөн бүс нутаг, дэлхийн хэмжээний гарааны бизнес, хурдасгуур хөтөлбөр, хөрөнгө оруулалтын уулзалт, хэлэлцээрт оролцох юм.



“ОЛОН УЛСЫН ЖДҮ ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭЛЭВ

Бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тогтвортой хөгжил, дэлхийн эдийн засгийн өсөлтөд оруулж буй хувь нэмрийг үнэлэн жил бүрийн 6-р сарын 27-нд “Олон улсын ЖДҮ өдөр”-ийг тэмдэглэдэг.

Монгол улсын Засгийн газраас энэ өдрийг угтаж 2024 оны 6-р сарын 11-16-ны өдрүүдэд долоо хоногийн турш БЖДҮ эрхлэгчдэд чиглэсэн олон арга хэмжээг зохион байгууллаа. “Олон улсын ЖДҮ-ийн өдөр”-ийг баярын өдөр гэхээс илүү ЖДҮ эрхлэгчид харилцан мэдлэгээ хуваалцах, хамтын ажиллагааны сүлжээг хөгжүүлэх, бизнесийн өсөлт хөгжилтийг тэтгэх энтрепенёр сэтгэлгээг хөгжүүлэх цогц арга хэмжээ болгон тэмдэглэв. Эдгээр үйл ажиллагааг GIZ ийн ICED төсөл нь “Нийслэлийн Жижиг, Дунд Үйлдвэр, Үйлчилгээг Дэмжих Төв”-тэй хамтран хэрэгжүүлэв.

Монгол улсын 21 аймгийн 400 орчим ЖДҮ эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг Чингисийн талбайд нийт 120 асар, 14 Монгол гэрт байрлуулан олон нийтэд таниулан сурталчилж, ЖДҮ эрхлэгчид таван өдрийн хугацаанд нийтдээ 500 гаруй сая төгрөгийн борлуулалт хийжээ.

ЖДҮ-ийн тогтвортой өсгөлтийг хангах, бүтээлч байдлыг дэмжихэд бид хамтран ажиллаж байна. Хамтдаа үнэ цэнтэй ирээдүйг бүтээцгээе.



ЭЗХЯ-НЫ АЛБАН ХААГЧИД ТУРШЛАГА СУДЛАВ



Эдийн засаг, хөгжлийн яамны албан хаагчид Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашиг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлтийг боловсруулах чиглэлээр 2024 оны 6 дугаар сарын 3-12-ны өдрүүдэд Швейцарын Холбооны Улс, Норвеги, Шведийн Хаант Улсад туршлага судаллаа.




Тус аяллаар дээрх орнуудын Сангийн яам, Худалдаа, үйлдвэр, загас агнуурын яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам зэрэг байгууллагуудад зочилж, тэргүүн туршлагатай танилцан цаашдын хамтын ажиллагааны эхлэлийг тавив.

ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ БАТЛАВ

Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын А/26 тоот тушаалаар GIZ-ийн ICED төслийг амжилттай хэрэгжүүлэх, төслийн тогтвортой байдлыг хангах үүрэг бүхий удирдах хорооны бүрэлдэхүүнийг батлав. Удирдах хорооны гишүүддээ амжилт хүсье.



GIZ-ТАЙ ХАМТ АЖИЛЛАСАН ЖИЛҮҮДЭД БАЯРЛАЛАА




Монгол дах GIZ-т 18 жил үр бүтээлтэй ажилласны эцэст ноён Д.Ёндонжамц (Ёогий) амьдралынхаа шинэ хуудсыг эхлүүлж байна.

Ёогий 2006 онд “Бүс нутгийн эдийн засгийг дэмжих” хөтөлбөрт жолоочоор ажиллаж эхэлсэн цагаас хойш Боловсрол, Байгаль орчин, Тогтвортой хөгжлийн боловсрол, Ногоон хөгжил, ЖДҮ, бүс орон нутгийн хөгжлийн чиглэлээр хэрэгжиж байсан төсөл, хөтөлбөрүүдэд ажиллаж, тасралтгүй өсөж, хөгжиж 2024 оноос ICED төслийн ахлах зөвлөхийн албан тушаалд ажилласан.

Ёогийгийн ажлын гүйцэтгэл, эрч хүч, урам зориг, хүн бүхэнтэй нийцтэй харилцдаг чадвар нь ажилласан төсөл, хөтөлбөрүүдийн амжилтанд бодит хувь нэмэр болж ирсэнийг тэмдэглэн хэрээд таатай байна.

GIZ-ийн ICED төслийн хамт олон Ёогийдоо шинэ ажил, бизнест нь өндөр амжилт хүсэн ерөөе! Цаашдын амьдрал нь аз жаргалаар дүүрэн байх болтугай!

ЭДИЙН ЗАСГИЙН ОЛОН ТАЛТ ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ (ICED) ТӨСӨЛ



Нийтэлсэн: Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны
Нийгэмлэг (GIZ)

Огноо: 2024 оны 7-р сар

Дизайн/Зураг: GIZ ICED төсөл

Холбоо барих: Г. Бүдханд
“Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих”
төсөл
3-р давхар, 38-р байр, Нэгдсэн Үндэстний
гудамж, 4-р хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот 210646, Монгол улс

Утас: (+976) 77117704

И-мэйл: gurtsog.budkhand@giz.de

Веб: www.giz.de/mongolia